



2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/420

Зуунмод

Газар эзэмших эрхийг баталгаажуулж,
газрын хэмжээг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37.1, 37.2, Монгол улсын засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт байрлах Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль /9058869/-д сургуулийн барилга, биеийн тамирын талбай, сурагчдын дотуур байрны зориулалтаар 1-р багт 38121 м², 2-р багийн нутагт 7527 м², нийт 45648 м² газрыг нэгтгэн нэг захирамжаар эзэмшүүлснийг хавсралтад дурьдсаны дагуу нэгж талбар тус бүрээр өөрчлөн тогтоож Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль /9058869/-д 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль /Л.Эрдэнэцэцэг/-д дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.


2.2. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.3. Холбогдох хууль тогтоомж, хэсэгчилсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 570 дугаар захирамж болон газар эзэмших эрхийн 0235054, 0235057, 0235059 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 000012

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дүгээр сарын 26-ны өдрийн
А/120 дугаар захирамжийн
хавсралт

д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистр	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ \м2\	Зориулалт	Байршил
1	Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль	9058869	4110062522	3152	Сургуулийн дотуур байр	6-р баг, Ирээдүй хотхон, Лувсангомбын гудамж, 227 тоот
2	Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль	9058869	4110062523	7989	Сургууль	6-р баг, Ирээдүй хотхон, Лувсангомбын гудамж, 235 тоот
3	Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль	9058869	4110062524	8999	Сургууль, цэцэрлэг	6-р баг, Ирээдүй хотхон, Зуунмодны гудамж, 224 тоот
4	Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль	9058869	4110062575	14713	Сургууль	1-р баг, Солонго хотхон, Рашааны гудамж, 100 тоот
	НИЙТ			34853м2 \3,48 га		